

БАТЛАВ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Б.БАТЗАЯА

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

2014.03.20

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

№	Хэлэлцэх асуудал	Танилцуулах ажилтан
1	Компанийн гүйцэтгэх захирлыг ажлаас чөлөөлж, томилох тухай	ТУЗ-ийн дарга Б.Батзаяа
2	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулж батлах	Захиргааны хэлтсийн дарга М.Гантөгс
3	Компанийн дэд захирал томилон ажиллуулах талаар	ТУЗ-ийн дарга Б.Батзаяа

Хурлын шийдвэр: Хурлын тогтоол, тэмдэглэл гарна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Б.Амгалан

**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 03 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 06


Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.9 дэх заалт, Төрийн Өмчийн Хорооны 2014 оны 150 дугаар тогтоол болон 2014 оны 03 сарын 20-ны өдрийн 2/772 тоот удирдамжийг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Пүрэвдорж овогтой Бат-Эрдэнийг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас 2014 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлж, хөлсөөр ажиллах гэрээг цуцласугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.БАТЗАЯА

**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 03 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.9, 7.3.10, 8 дугаар зүйлийн 8.5 дахь заалт, Төрийн Өмчийн Хорооны 2014 оны 150 дугаар тогтоол болон 2014 оны 03 сарын 20-ны өдрийн 2/772 тоот удирдамжийг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Пүрэвсамбуу овогтой Батсайханыг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэгт ажилд 2014 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. П.Батсайхантай “Хөлсөөр ажиллах гэрээ” байгуулахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Б.Батзаяад үүрэг болгосугай.

3. Холбогдох хууль тогтоомж болон Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй байгуулсан “Хөлсөөр ажиллах гэрээ”-нд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллахыг П.Батсайханд үүрэг болгосугай.

4. П.Батсайханд гүйцэтгэх захирлын албан тушаалын цалин, бусад нэмэгдлийг “Хөлсөөр ажиллах гэрээ”-нд заасан нөхцөлөөр зохих журмын дагуу тооцон олгохыг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн ерөнхий нягтлан бодогч Б.Ганбатад зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.БАТЗАЯА

**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 03 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Ажил хүлээлцүүлэх комисс
байгуулах тухай

Төрийн өмчийн хорооны 2014 оны 150 дугаар тогтоол, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2014 оны 06 болон 07 дугаар тогтоолыг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын ахлагч: Б.Батчулуун /ТӨХ-ны мэргэжилтэн, “МТЗ” ТӨХК-ийн ТУЗ-ийн гишүүн/


Гишүүд: М.Гантөгс /“МТЗ” ТӨХК-ийн захиргааны хэлтсийн дарга/

Б.Ганбат /“МТЗ” ТӨХК-ийн ерөнхий нягтлан бодогч/

2. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэгт ажлын ажлын нэг хоногт багтаан зохих журмын дагуу хүлээлцүүлж, тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулахыг Ажил хүлээлцүүлэх комисс /Б.Батчулуун/-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.БАТЗАЯА



**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 03 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн зохион байгуулалтын
бүтэц, орон тоо, 2014 оны бизнес төлөвлөгөө
батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.2, 7.3.3 дахь заалт, Төрийн Өмчийн Хорооны 2014 оны 72 ба 150 дугаар тогтоол, тус хорооны 2014 оны 03 сарын 14-ний өдрийн 2/720 тоот, 03 сарын 20-ны өдрийн 2/772 тоот удирдамжийг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны өөрчлөлтийг нэгдүгээр хавсралтаар, компанийн үндсэн үйл ажиллагааны 2014 оны бизнес төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан компанийн зохион байгуулалтын бүтцийн төслийн хэлтсийн захиргааны зардлыг төслийн санхүүжилтээс санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал П.Батсайханд зөвшөөрсүгэй.

3. Компанийн 2014 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, бизнес төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал П.Батсайханд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.БАТЗАЯА

**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 03 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 10.

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Төрийн Өмчийн Хорооны 2014 оны 150 дугаар тогтоол, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Пүрэвдорж овогтой Бат-Эрдэнийг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн төслийн үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирлын албан тушаалд 2014 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Гүйцэтгэх захирлын эзгүйд орлох эрхийг төслийн үйл ажиллагаа эрхэлсэн дэд захиралд олгосугай.

3. Холбогдох хууль тогтоомжийн дагуу П.Бат-Эрдэнэтэй гэрээ байгуулан ажиллахыг гүйцэтгэх захирал П.Батсайханд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.БАТЗАЯА